“Хатгах төөнөх тэргүүнтэн хураасан ном дэвтэр” сурвалж зохиол дахь зарим өвөрмөц хатгах аргыг тодруулан тайлбарласан үр дүн

С.Отгонбаяр[1], Ш.Болд[2], З.Болортулга[1]

[1]АШУҮИС, МАУОУС, Уламжлалт эмчилгээний тэнхим
[2]АШУҮИС, МАУОУС, Монгол Анагаах Ухаан Судлалын тэнхим
Цахим шуудан: serodotgonbayar93@gmail.com, Утас: 94928455

Түлхүүр үг:

Зүү хатгах арга
Дан найман хатгах арга
Нөхөх хасах хатгах арга

Товч утга:

Үндэслэл: “Хатгах төөнөх тэргүүнтэн хураасан ном дэвтэр” сурвалж зохиол нь анх МЭ 1601 он Мин улсын үед 10 боть 207 бүлэг бичигдсэн, зүү төөнө заслын агуулгыг бүхэлд нь багтаан, асуулт хариулт шүлэглэл хэлбэрээр бичигдсэн томоохон цогц эх сурвалж бүтээл юм[1]. Уг сурвалж зохиолоор дамжин ХАУ-ны зүү, төөнө эмчилгээ анх баруун монголд дэлгэрч, 1660-аад оны үед хятад хэлнээс 4, 6 дугаар боть нь тод монгол үсгээр “Хатгах төөнөх тэргүүтэн хураасан ном, дэвтэр” нэртэйгээр орчуулагдсан байна[5]. эртний монголчуудаас өнөөг хүртэл зүү төөнө эмчилгээ нь манай орны анагаах ухааны салбарт тодорхой хэмжээгээр нэвтэрсэн боловч өнөөгийн багш, судлаач, оюутан суралцагчдын гар дээр монгол хэлнээ илүү ойлгомжтой, тод томруун судалгааны ажлууд хийгдээгүй байна. Уламжлалт анагаах ухааны зүү төөнө засалтай холбоотой түүх, хөгжлийн талаар дурдсан ололттой талууд байгаа хэдий ч эртний ном судрыг Монгол үндэстэн өөрийн хэлээр бичиж орчуулсан, орчуулгын зохиол болон үндсэн эх сурвалжийн харьцуулсан, дүн шинжлэл хийсэн судалгаа хомс байгаа нь бидний судалгааны үндэслэл болж байна. **Зорилго: “**Хатгах төөнөх тэргүүтэн хураасан ном, дэвтэр” сурвалж зохиол дах өвөрмөц зүү хатгах аргууд, нөхөх хасах хатгах аргын онцлогийг тодруулан харьцуулан судлах. **Арга, аргачлал:** Бид судалгаандаа “Хатгах төөнөх тэргүүтэн хураасан ном дэвтэр” хятад эх сурвалж зохиолын 4 дүгээр ботийн агуулга дах зарим өвөрмөц хатгах аргын онцлогийг тодруулж, бусад эртний сурвалж зохиолтой эх бичиг сурвалж судлалын харьцуулах аргаар, магадлан жагсаах аргаар төрөлжүүлэн онцлогийг тодруулж, өвөрмөц үг хэллэгийг задлан шинжлэн тайлбарлаж, нэгтгэн дүгнэх аргыг ашиглан хатгах арга, нөхөх хасах хатгах зарчим, дан болон хавсарсан хатгах аргуудын онцлогийг тодруулав. **Үр дүн:** Бидний судалгаанд “Хатгах төөнөх тэргүүтэнг хураасан ном, дэвтэр” зохиолд бичигдсэн өвөрмөц хатгалтын арга нь Мин улсын өмнөх үеийн оточ нарын туршлагад үндэслэн сүвийг олох, хумслах, доргиох, сэгсрэх, хаах, тараах, имрэх, үрэх “дан найман арга”-ыг тодруулав[7]. Имэрч эргүүлэх, доргиох, сэгсрэх, хаах аргууд нь Доү Хан Чин эмчийн 4 аргатай үйлдлээрээ төстэйг тодруулав. Дан найман арга нь Ян Жи Жоү эмчийн зүү нөхөх, хасах хатгах аргын үндсэн зарчим болохыг бүтээлээс илрүүлэв. Мөн зүүний өнгөц, гүн хатгах хэмжээг онолын үндэслэлтэйгээр их нөхөж хасах, бага нөхөж хасах арга гэж 2 ангилсан байна. Тэрээр нөхөх хасах аргын үйлдлийн техник нь зүү хатгах хүч, далайц, зүүний гүн хатгалтын хэмжээнээс хамаарна гэсэн санааг дэвшүүлсэн байна. Тус бүтээлд “Зүү хатгалт нь хэмжээтэй” гэж тэмдэглэсэн нь зүү хатгах арга, техник түүний шинж чанар, онцлог, зүүний сүв дээрх цочролыг хүлээн авч буй хариу урвал зэргээс хамаарч зүүг нөхөх хасах хатгах арга нь харилцан адилгүй үйлдэл үзүүлж болох юм. Өөр өөр хатгах аргачлал, хатгалтын шинж чанар, хэмжээ зэргээс нөхөх хасах аргын үр дүн харилцан адилгүй байна гэсэн үр дүнг илэрхийлж буйг тодруулав. **Дүгнэлт:** 1. Дан найман аргын имэрч эргүүлэх, доргиох, сэгсрэх хаах аргууд нь Доү Хан Чин оточийн 4 аргатай хатгах үйлдлээрээ ижил төстэй бусад аргууд нь ялгаатай байв. 2. “Зүү нөхөх хасах арга нь хэмжээтэй” зарчим нь《针灸大成》Zhen jiu da cheng,《神应经》Shen ying jing сурвалж зохиолуудад нэршил төст боловч агуулгын хувьд зөрүүтэй байна. Нөхөх хасах арга, аргачлал нь зүү хатгах хүч, далайц хэмжээнээс хамаарч эмчилгээний үр дүн харилцан адилгүй байна.

Үндэслэл: “Хатгах төөнөх тэргүүнтэн хураасан ном дэвтэр” сурвалж зохиол нь анх МЭ 1601 он Мин улсын үед 10 боть 207 бүлэг бичигдсэн, зүү төөнө заслын агуулгыг бүхэлд нь багтаан, асуулт хариулт шүлэглэл хэлбэрээр бичигдсэн томоохон цогц эх сурвалж бүтээл юм[1]. Ялангуяа тус бүтээлийн 4, 5 дугаар ботийн агуулгад зүүг хатгах багаж, хатгах аргачлал, зүүг нөхөх хасах хатгах аргын талаар онцгойлон өгүүлсэн байдаг.

Нэрт оточ Ян Жи Жоү өөрийн бүтээлдээ зүү, төөнө эмчилгээ, хятад эм, бариа засал, аливаа өвчний хам шинжийн ялган оношилгоог дурдсанаас гадна зүү хатгах үндсэн арван хоёр хатгалтын арга, дан найман арга, нийлмэл хорин дөрвөн арга, зүүг хатгаж оруулах хэмжээний тухай, зүү эмчилгээний жор найруулах зарчимд ойролцоо тохирох сүвийг хослуулан сонгох, олон төрлийн нийлмэл жорыг зүү хатгах аргуудаар баяжуулан тэмдэглэн бичжээ. Энэхүү бүтээл нь Хятад Япон, Герман, Франц зэрэг 47 орны хэлээр орчуулагдан 79 төрөл хэлбэрээр хэвлэгдсэн гэж зарим судлаачид үзэж байна[2,3,4]. Уг сурвалж зохиолоор дамжин ХАУ-ны зүү, төөнө эмчилгээ монголд дэлгэрч, 1660-аад оны үед хятад хэлнээс 4, 6 дугаар боть нь тод монгол үсгээр “Хатгах төөнөх тэргүүтэн хураасан ном, дэвтэр” нэртэйгээр орчуулагдсан[5].

Эртний монголчуудаас өнөөг хүртэл зүү төөнө эмчилгээ нь манай орны анагаах ухааны салбарт тодорхой хэмжээгээр нэвтэрсэн боловч өнөөгийн багш, судлаач, оюутан суралцагчдын гар дээр монгол хэлнээ илүү ойлгомжтой, тод томруун судалгааны ажлууд, уламжлалт эмчилгээний эмнэл зүйн судалгаа хийгдээгүй байна. Уламжлалт анагаах ухааны зүү төөнө засалтай холбоотой түүх, хөгжлийн талаар дурдсан ололттой талууд байгаа хэдий ч эртний ном судрыг Монгол үндэстэн хэдий үеэс эхлэн өөрийн хэлээр бичиж орчуулсан, орчуулгын зохиол болон үндсэн эх сурвалжийн харьцуулсан, дүн шинжлэл хийсэн судалгаа хомс байгаа нь бидний судалгааны үндэслэл болж байна.

Зорилго: “Хатгах төөнөх тэргүүтэн хураасан ном, дэвтэр” сурвалж зохиол дах өвөрмөц зүү хатгах аргууд, зүү нөхөх хасах хатгах аргын онцлогийг тодруулан харьцуулан тайлбарлах.

Зорилт:

1. “Хатгах төөнөх тэргүүтэн хураасан ном дэвтэр” сурвалж зохиолын 4 дүгээр ботийн агуулгын өвөрмөц хатгах дан найман аргын онцлогийг тодруулж, бусад эх сурвалжтай харьцуулан, тайлбарлах.
2. Эх сурвалж зохиолын 4 дүгээр ботийн агуулга дах нөхөх хасах, хатгах аргын онцлогийг тодруулж, бусад эх сурвалжтай харьцуулан тайлбарлаж, уялдаа холбоог тодруулах.

Арга, аргачлал: Бид судалгаандаа “Хатгах төөнөх тэргүүтэн хураасан ном дэвтэр” сурвалж зохиолын 4 дүгээр ботийг хэрэглэгдэхүүн болгон, бусад эх сурвалж зохиолуудтай эх бичиг сурвалж судлалын харьцуулах аргаар харьцуулан, магадлан жагсаах аргаар төрөлжүүлэн онцлогийг тодруулж, өвөрмөц үг хэллэгийг задлан шинжлэн тайлбарлаж, нэгтгэн дүгнэх аргыг ашиглан хатгах арга, нөхөх хасах хатгах зарчим, дан, хавсарсан нийлмэл хатгах аргуудыг тодруулав.
Бид судалгаагаа АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2021 оны 10 сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу (№2021/3-10) эхлүүлж хийж гүйцэтгэв.

Үр дүн: Бид “Хатгах төөнөх тэргүүтэнг хураасан ном дэвтэр” сурвалж зохиолын 4 дүгээр ботийн агуулга дах зарим өвөрмөц хатгах аргын онцлогийг тодруулж, хятад эх сурвалж зохиолуудтой харьцуулан тайлбарлаж, уялдаа холбоог тодруулав.

1. Өвөрмөц дан найман аргыг тодруулан, харьцуулан судалсан үр дүн: Ян Жи Жоү нь тухайн бүтээлдээ өмнөх үеийн оточ нарын болон өөрийн эмнэл зүйн туршлагат үндэслэн зүү хатгах 12 хатгалтын арга Доү Хан Чин эмчийн 14 аргыг эмхэтгэн оруулж, хумслах, доргиох, сэгсрэх, хаах, тараах, имрэх, үрэх гэсэн “Дан найман арга”-ыг бусад эх сурвалжуудад өвөрмөц хатгах арга хэмээн нэгтгэн дүгнэжээ[7]. (Хүснэгт 1)

Хүснэгт 1 . Өвөрмөц хатгах дан найман аргын хий цусны гүйдлийг идэвхжүүлэх үйлдэлтэй аргуудыг тодруулан бусад эх сурвалжтай харьцуулсан үр дүн

	Олох арга	Хумслах	Тараах арга
针灸大成 **Zhen jiu da cheng**	“Тухайн сүвийг гараар дарж тэмтрэн, сүв булчин ясанд тэмтрэгдэж байвал сүвийг зөв зүйтэй олжээ.”	金针赋*: “зүүн гараар сүвийг хүчтэй хумсалж даран, хамгаалах, тэжээлийн эрчим хүчийг гэмтээхгүйн үүднээс хий цусыг нэвтрүүлэн тараана.”	“Зүүг хасаж хатгахдаа хуруугаар сүвээс 4 тийш тэмтэрч хий цусны гүйдлийг тарааж нэвтрүүлнэ”
Бусад эх сурвалж		医学入门*: “Дарах арга, хумсаар тухайн сүвийн 4 талд дарж хонхойлгоно”	内经 Neijing*сударт: Зүүг хасаж хатгахдаа хуруугаараа зүүний сүвээс 4 тийш зурах байдлаар хий цусны гүйдлийг тараана”
Тайлбар	Биологийн идэвхит сүвээр дамжуулан эмгэг хариу урвалыг оношлох, сүв сонгох боломжтой	Тус арга 2 үүрэгтэй: Хий цусны гүйдлийг нэвтрүүлж зүү орох өвдөлтийг багасгах. Судас, яс булчинг тусгаарласнаар гэмтэх эрсдэлээс сэргийлэх.	Сувгийн эрчим хүчийг өдөөх, зүүг хатгахад зүүний мэдрэмж ирүүлэх, хий гүйдлийг сувагт дамжуулах эмчилгээний үйлдэл өндөртэй арга юм.

Тайлбар:《金针赋》*Jin Zhen Fu-Алтан хатгуурын увдис*
《医学入门》*Yi Xue Ru Men - Мин Ли Чаны 1575 онд бичигдсэн ХАУ-ны сурвалж бүтээл*
《黄帝内经》*Huang Di Nei Jing - Хятад анагаах ухааны хамгийн эртний сурвалж бүтээл*

Энэхүү дан найман арга тус бүрийг тухайн өвчний нөхцөл байдалд тулгуурлан, дангаар эсвэл хавсарч ашиглан нөхөж хасаж хатгах нь эмчилгээний үр дүнтэй болохыг тодруулав. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Өвөрмөц хатгах дан найман аргын нөхөх хасах хатгах үйлдэлтэй аргуудыг тодруулан бусад эх сурвалжтай харьцуулсан үр дүн

	针灸大成 **Zhen jiu da cheng**	Бусад эх сурвалж	Тайлбар
Доргиох арга	“Зүүг доргион, хийн мэдрэмж ирэх хүртэл зүүг бага зэрэг буцаан татаж, гаднаас дотогш өнгөц дараа нь гүн оруулах нь нөхөх арга юм.”	内经*: “Уур мэт доргион чичиргэх” 针经指南*: “Зүүг эрхий хуруугаар доргиож нөхөж хатгана” 金针赋: “Хооснуг нөхөхөд зүүг доргионо”	Арга билгийг тэгшитгэх, хамгаалах тэжээлийн хийн гүйдлийг нөхөх үйлдэлтэй арга юм.
Сэгсрэх арга	“Зүүний толгойг сэгсрэн, зүүг бага зэрэг буцаан татаж гүн оруулан өнгөц хэсэг рүү дотроос гадагш татах нь хасах арга юм.”	灵枢*: “Зүүг сэгсрэн, эмгэг эрчим хүчийг гадагш хөөх	Хийн мэдрэмжийг сувагт тархаан янгийн ихсэлтийг гадагшлуулах хасах эмчилгээний үйлдэлтэй арга юм.
Хааж бөглөх арга	内经*сударт: зүүг сугалахад нөхөх арга нь, биеэс эрчим хүчийг гадагш гаргахгүй, хий цусны хоосон үүсгэхгүйн тулд сүвийг дарж бөглөх арга юм.”	素问*: сударт тэмдэглэхдээ “Гараар дарж хийн урсгалыг хааж, нөхөх”	Зүүг сугалсаны дараа сүвийг дарсанаар өвдөх, бадайрах зэрэг зовуурийг бууруулах, цус тогтоох, зүү хатгалтын хүндрэлээс сэргийлэх арга болно.
Имрэх арга	“Дээд биеийг эмчлэх үед зүүг гадагш имрэх, доод биеийг эмчлэх үед дотогш имэрнэ.”		Имрэх арга 2 үүрэгтэй: Зүүний мэдрэмжийг хянах, суваг хэрдсээр хийн гүйдлийг өдөөж дамжуулах
Имэрч эргүүлэх арга	“Зүүг имэрч эргүүлэхэд, эрхий хуруу дээшлүүлэн баруун тийш эргүүлэх нь нөхөх, эрхий хуруу доошлуулж, зүүн тийш ухраах нь хасаж хатгах арга юм.”	Ян Жи Жоугийн 12 хатгалтын аргын “имрэх” арга зөвхөн эрчим хүчийг “гадагш хөөх” үүрэгтэй гэжээ.	Тус аргын чиглэлийн ялгааг үндэслэн “зүүн тийш имэрч эргүүлвэл нөхөх, баруун тийш бол хасах арга” санааг дэвшүүлсэн байдаг.

Тайлбар:《黄帝内经》*Huang Di Nei Jing – ХАУ-ны хамгийн эртний сурвалж бүтээл*
《内经*素问》*Su Wen - Нэйжин судрын үндсэн нэгдүгээр бүлэг.*
《内经*灵枢》*Ling Shu -Нэйжин судрын хоёрдугаар бүлэг.*
《针经指南》*Zhen Jing Zhi Nan - Доу Жи Жуаны 1295 онд бичигдсэн гарын авлага*

Зүүг хатгах дан найман аргын сүвийг хайж олох аргыг ашиглахдаа “Тэжээлийн эрчим хүчийг идэвхжүүлэн, хамгаалах эрчим хүчийг гэмтээлгүйгээр хатгахад, зүүний сүвийг хуруугаар дарж, хийн гүйдлийг тарааж, зүүг хатгах; хамгаалах эрчим хүчийг идэвхжүүлэн тэжээлийн эрчим хүчийг гэмтээлгүйгээр хатгахад, сүвийг оновчтой сонгон, зүүг хөндлөн хатгах ёстой” гэжээ[9]. Хумслах арга нь Доү Чи оточийн《针经指南》сурвалж дах 2 гар оролцдог хумслах, дарах, тараах аргуудын үйлдлийн техниктэй холбоотой агуулгыг эх сурвалжид нэмэн оруулж бичсэн байна.《难经》Nanjing сударт: “Зүүг мэдэх, зүүн талдаа итгэх” буюу зүүн, баруун 2 гараа оролцуулан нөхөх, хасах хатгах аргын тухай өгүүлжээ[8].

2. Нөхөх хасах хатгах аргатай холбоотой агуулгын онцлог, бусад эх сурвалжтай харьцуулан судалсан үр дүн: Эртний нөхөх хасах аргын гүн өнгөц хэмжээг Ян Жи Жоү өөрийн бүтээлдээ тусган "зүү нөхөх хасаж хатгах нь хэмжээтэй байдаг" гэсэн зарчмыг тодорхой дурдсан байна. Зүүг хатгахад зохистой гүнд, хүчтэй далайцаар зүүг өргөж түлхэж нөхөх хасах аргыг хэрэглэх нь их нөхөх хасах, зохистой гүнд хүч багатай далайцаар зүүг хатгах нь бага нөхөж, хасах хатгах арга болно. Тиймээс Ян Жи Жоү бүтээлдээ аливаа нөхөх хасах арга нь түүний хатгах хүч далайц, хатгалтын хэмжээнээс хамаарна гэсэн санааг дэвшүүлсэн байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Зүү хатгах хэмжээг эртний сурвалж зохиолуудад харьцуулсан үр дүн

《神应经》**"Shen ying jing"**	针灸大成 **"Zhen jiu da cheng"**
1. "平补平泻" зүүг тэгш нөхөж тэгш хасах хатгах тухай хамгийн анх бичигдсэн 2. "Зүүг хатгахдаа эхлээд хасч, дараа нь нөхөж хатгах" 3. Эхлээд өвчин үүсгэгчийг биеэс гадагшлуулан хасч, эрчим хүчийг нөхөх нь "тэгш нөхөж хасах арга" юм.	1. Зүү нөхөх хасаж хатгах нь хэмжээтэй 2. Зүү нөхөж хасах хатгах аргын хэмжээг их, бага гэж 2 хуваасан 3. Нөхөх хасах арга болон үйлдлийн техник нь түүний хатгах хүч далайц болон хэмжээний ялгаанаас хамаарна гэсэн санааг дэвшүүлсэн

Тайлбар: 平补平泻- *тэгш нөхөх, тэгш хасаж хатгах арга*
神应经 *Shen yin jing*- ХАУ-ны эртний сурвалж бүтээл*
针灸大成 *Zhen jiu da cheng*- 1601 онд бичигдсэн ХАУ-ны эртний сурвалж бүтээл*

《灵枢》Ling Shu сударт хасах арга хатгалтын хэмжээ чадал их байна, нөхөх арга хатгалтын хэмжээ чадал бага байна.《千金翼方》сударт "зүүг хатгаж цочроох хэмжээ их бол нөхөх арга, цочроох хэмжээ хөнгөн бага бол хасах арга" гэж тэмдэглэгдсэн байдаг. Эдгээр үзэл санаа хоорондоо эсрэгцэж байгаа хэдий ч өөр өөр хатгах арга, хатгалтын шинж чанар, хэмжээнээс нөхөх хасах аргын үр дүн харилцан адилгүй байна гэсэн нэгдсэн үр дүнг илэрхийлж буйг тодруулав.

3. Зүүг хатгах арга болон хамгаалах эрчим хүч weiqi, тэжээлийн эрчим хүч yingqi, суваг хэрдэс хоорондын уялдаа холбоог тодруулсан үр дүн: Оточ Ян Жи Жоү нөхөх хасах аргыг 2 хэсэг болгон ангилсан байна[10]. Нэгдүгээрт, суваг хэрдсийн урсгалыг дээш доош нэвтрүүлэх арга: Жишээ нь, имрэх эргүүлэх арга. Хий цусны гүйдэл сувгийн дагуу урсахад үүсэх эрчим хүчний илүүдэл, дутагдлыг арилгах үйлдэлтэй. Хоёрдугаарт, тэжээлийн болон хамгаалах эрчим хүчийг гадагш дотогш нэвтрүүлэх арга: түргэн аажим нөхөх хасах арга, өргөж түлхэх нөхөж хасах арга. Хамгаалах, тэжээлийн эрчим хүчний дүүрэн хоосон хам шинжийг анагаан тэнцвэржүүлэх зорилготой. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Зүүг хатгах арга болон хамгаалах эрчим хүч, тэжээлийн эрчим хүч, суваг хэрдэсийн хийн урсгалын хооронд уялдаа холбоог тодруулсан үр дүн

《针灸大成》**Zhen jiu da cheng**	《难经》**Nan Jing Нанжин судар**	《内经》**Nei Jing Нэйжин сударт**
"经络迎随设为问答" хэсэгт тодорхой тэмдэглэсэн нь: "Тэжээл, хамгаалах эрчим хүч нь арга билиг юм.	"Нөхөх хасах хатгах аргууд нь, арга билиг, суваг хэрдэс, тэжээл болон хамгаалах эрчим хүчний урсгал чиглэлээс хамаарна"	《内经》сударт: "Хасах арга дотроос гадагш, зүүг гүнээс өнгөц хэсэг рүү хатгах, нөхөх арга зүүг биеийн өнгөц хэсгээс гүн рүү аажим оруулан сувгийн эрчим хүчийг нэвтрүүлнэ. Тэжээлийн болон хамгаалах эрчим хүч нь эрчим хүчний орох гарах хаалга юм." гэжээ.

Хэлцэмж: ХАУ-нд зүү хатгах арга нь зүүг өргөж түлхэх, оруулах, эргүүлэх техникийг үндсэн техникээ болгон ашигладаг ба хатгалтын гүн, чиглэл, хугацаа, хүндийн зэрэг, далайц зэргээс хамаарч хүний биеийн арга билгийн эрчим хүчний хөдөлгөөнөөр өвчний хоосон хам шинжийг нөхөх, дүүрэн хам шинжийг хасах үйлдлээр эмчилгээний үр дүнг үзүүлдэг[6]. Huang Xue Cheng[15] нарын "Мин улсын үеийн оточ нарын зүү хатгах аргын онцлог" судалгаанд оточ бүрийн зүү хатгах арга, техникийн онцлогийг хооронд харьцуулсан байна.

Ян Жи Жоү нь өмнөх үеийн оточ нар болон өөрийн туршлагат үндэслэн зүүг хатган оруулах, хумслах, доргиох, сэгсрэх няслах, хаах, тараах, имрэх, үрэх гэсэн "дан найман арга"-ыг нэгтгэн дүгнэжээ[7]. "Хатгах төөнөх тэргүүтэн хураасан ном дэвтэр" сурвалж зохиолын 4 дүгээр ботийн агуулга дах зүү хатгах "дан найман арга"-ыг Доү Хан Чин оточийн 14 арга, Ян Жи Жоү өөрийн 12 хатгалтын аргатай эмхэтгэн тухайн аргуудын эмчилгээний үр нөлөө, үйлдлийн техниктэй холбоотой агуулгыг нэмэн баяжуулсан байна. Бусад нөхөж хасаж хатгах өвөрмөц, нийлмэл аргуудын суурь болох дан найман арга нь бусад сурвалж зохиолуудад харьцангуй ховор тохиолдсон төдийгүй эдгээр аргууд нь зүү нөхөх хасах хатгах аргын талаарх зохиогчийн үзэл санааг давхар дэвшүүлж буй юм. Ян Жи Жоү аливаа нөхөх хасах арга, үйлдлийн техник нь түүний хатгах хүч, далайц болон хэмжээнээс хамаарна гэсэн санааг дэвшүүлсэн нь эмнэл зүйн практикт зүүний их биеийн нарийн бүдүүн, хатгалтын гүн гүехэн, хатгах хүч, зүүг үлдээх хугацаа, өргөж түлхэх, имэрч эргүүлэх хэмжээ болон хурд зэрэг нь харилцан адилгүй, тиймээс аливаа нөхөх хасах аргыг хэрэглэхдээ дээрх хүчин зүйлүүдийг нягт нямбай үнэлж, дүгнэсний дүнд зүүг их, дунд, бага хэмжээгээр нөхөх хасах эсэхийг шийдвэрлэх ёстой.

Pei Qing Wang[16], Hong-sheng Xue[17] нарын судалгаануудад зүүний мэдрэмж ирэх, тухайн сүв дээр

хатгах арга ашиглан сувгийн дагуух хийн гүйдлийг идэвхжүүлэх эмчилгээний өндөр үр нөлөө үзүүлж болохыг өгүүлсэн. Гэсэн хэдий ч зүү нөхөх хасах хатгах болон хатгах хэмжээтэй холбоотой ойлголт эртнээс эдүгээг хүртэл өөр өөр байсаар ирсэн. Бидний судалгаанд Ян Жи Жоү бүтээлдээ "Зүү хатгалт хэмжээтэй" гэж тэмдэглэсэн нь эмнэлзүйн практикт, зүү хатгах арга техник түүний шинж чанар, хэмжээний онцлогоос гадна, зүүний сүвийн цочролыг хүлээн авах хариу урвал зэргээс хамаарч зүүг нөхөх хасах хатгах арга нь харилцан адилгүй үйлдэл үзүүлж эмчилгээний үр дүн гарах боломжтой юм. Өөр өөр хатгах техник, хатгах шинж чанар, хэмжээ зэргээс нөхөх хасах аргын үр дүн харилцан адилгүй байна гэсэн нэгдсэн үр дүнг тодруулав.

Дүгнэлт:

1. Тухайн зохиолд бичигдсэн Ян Жи Жоү-гийн Дан найман аргын имэрч эргүүлэх, доргиох, сэгсрэх болон хаах аргууд нь Доү Хан Чин оточ нарын 14 аргын доторх дөрвөн зүү хатгах аргатай үйлдлээрээ ижил төстэй ч бусад аргууд нь ялгаатай байв.
2. "Хатгах төөнөх тэргүүтэнг хураасан ном дэвтэр" зохиолд бичигдсэн "зүү нөхөх хасах хэмжээтэй" гэсэн ойлголт нь《神应经》сурвалж зохиолуудад ижил нэршлээр тэмдэглэгдсэн боловч онол, агуулгын хувьд хоорондоо зөрүүтэй тэмдэглэгдсэн байна. Гэсэн хэдий ч аливаа нөхөх хасах арга, үйлдлийн техник нь түүний хатгах хүч далайц болон хэмжээнээс хамаарна гэсэн нэгдсэн ойлголтонд хүрч болохуйц байна.

Талархал: Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд тусалж дэмжсэн АШУҮИС, МАУОУСургуулийн багш нарт гүнээ талархал илэрхийлье.

Ном зүй:

1. 杨继洲，针灸大成*卷四，北京：人民卫生出版社出版，*1963*
2. 李志刚.《针灸大成》对针法灸法的贡献 [J]. 针灸临床杂志，2005.21（10）：3
3. 吴富东. 针灸医籍选读. 北京：中国中医药版社. 2014：2
4. 张晶，田思胜，《针灸大成》文献研究. 2009
5. *Ш. Батсайхан. Хатгах төөнөх тэргүүнтэнг хураасан ном дэвтэр. Улаанбаатар. 2009*
6. 向华，郭长青. 杨继洲针刺手法学术渊源考辨. 北京，2007：24
7. 向华，郭长青. 杨继洲针刺手法学术渊源考辨. 北京，2007：20-21
8. 吴富东. 针灸医籍选读. 北京：中国中医药版社. 2014：138-139
9. 杨继洲，针灸大成*卷四，北京：人民卫生出版社出版，1963. 1:109-110
10. 吴月琴 . 试论杨继洲的针刺补泻特点 [J]. 江苏中医，1994，15(12):32-33.
11. 赖张凤，海外回归中医古籍《针灸大成》流传及版本研究. 2015.10(11):1611-1612
12. 谭小春. 针灸大全. 山西. 山西出版集团，2011.10
13. 董勤胡葵，小议得气与针刺补泻之关系，南京中医药大学学报，1998.14（1）
14. 试论针刺平补平泻法，中医杂志，浙江省中医药研究所. 1982：46-47
15. 黄雪呈，明代医家针刺手法，广州中医药大学，2010
16. *Pei-qing Wang, Deqi and application and manipulation of Deqi. Section of TCM, Yanzhou Municipal Railway Hospital, Shandong, China. 2007 May*
17. *Hong-sheng Xue, Xiao-li Fang, Brief talk on manipulation and clinical application of Yang Ji-zhou's "through joint crossing meridians" needling method. Chang Gung Memorial Hospital and Chang Gung University College of Medicine, Taiwan, China. 2009 Mar*

The results of a study comparing some sources of acupuncture in “Great Compendium of Acupuncture and Moxibustion” literature

Otgonbayar S[1], Bold Sh[2], Bolortulga Z[1]

[1]Department of Traditional Therapy, ISMM, MNUMS
[2]Department of Mongolian Medicine, ISMM, MNUMS
E-mail: Serodotgonbayar93@gmail.com, Tel: +976-94928455

Background: The “Great Compendium of Acupuncture and Moxibustion” is a comprehensive work that comprises ten volumes and 207 chapters written in the form of questions and answers during the Ming Dynasty in AD 1601. It played a significant role in introducing Traditional Chinese medicine acupuncture treatment to western Mongolia, and in the 1660s, the 4th and 6th volumes were translated into Clear Mongolian Script as “Great Compendium of Acupuncture and Moxibustion”, which has been influential in the field of acupuncture to this day. While acupuncture treatment has made its way into the medical field of our country, it has been challenging for today’s teachers, researchers, and students, as no comprehensive and extensive research on the subject in the Mongolian language has been made. While there have been some studies on the history and development of acupuncture in traditional medicine, the lack of ancient works written and translated into the Mongolian language makes it difficult to compare and analyze the translated texts and primary sources, which becomes the reason for our research.

Aim: To clarify and compare the characteristics of complementary and subtractive acupuncture methods and unique acupuncture methods in the “Great Compendium of Acupuncture and Moxibustion”.

Materials and Methods: Methods: In our research, we clarified the characteristics of some unique puncturing methods in the contents of the 4th volume of “The Great Compendium of Acupuncture and Moxibustion” Chinese literature, using the method of probabilistic list to clarify the characteristics, to analyze and explain the unique words, and to use the summarizing method to characterize the punctuation method, the principle of complementary and subtraction punctuation, single and combined punctuation methods are clarified.

Results: In our research, the unique acupuncture method written in the book “The Great Compendium of Acupuncture and Moxibustion” is based on the practical experience of physicians during the pre-Ming period, highlighting the “single eight methods” of finding points, clawing, vibrating, shaking, closing, spreading, twisting, and rubbing; clarifies that the methods of twisting, vibrating, shaking and closing are similar in action to the 4 methods of Dr. Dou Han Qing. The work revealed that the Single Eight Method is the basic principle of Yang Ji Zhou’s method of supplementing and subtracting acupuncture. Also, the length of superficial and depth of the needles is divided into 2 types based on the theory of high and low complementary subtraction method. He put forward the idea that the operation technique of the complementary subtraction method depends on the strength, amplitude and depth of the needling. According to the work, “Acupuncture is sizable” and depending on the method of puncturing technique, its characteristics, features, and the response to the stimulation of the acupuncture point, the complementary and subtraction acupuncture method can have a variety of effects. It is clarified that the results of the complementary subtraction method vary depending on different puncture methods, characteristics and sizes of punctures.

Conclusions:

1. Yang Ji Zhou’s Eight Techniques of Spinning, Shaking, Shaking, and Blocking were similar to Dou Han Qing Acupuncturist’s 4 Techniques of 14 Techniques.
2. “针灸大成" and "神应经" are marked with the same name in the literature, but it is marked with differences in theory and meaning.

Keywords: Needle punching method, Single eight punching method, Complementary subtraction punching method